

Гарчиг

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	1
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	13
2.1. ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ШААРДЛАГА	13
2.2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
2.3. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	13
БҮЛЭГ 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
БҮЛЭГ 4. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
БҮЛЭГ 6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
БҮЛЭГ 9. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
ХАВСРАЛТ	25

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


Төслийн нэр: “Хаягдал төмрийг хайлуулж ган туйван боловсруулах үйлдвэр” төсөл

“Эйч Ди Ти Эм” ХХК нь 2013 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 2014 онд Барилга хот байгуулалтын сайдын БМУ 197/14 тоот дугаар бүхий тусгай зөвшөөрлийг авч улмаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутагт 88051 м.кв талбайд хаягдал төмөр хайлуулж ган туйван үйлдвэрлэх үйлдвэрийг барьж байгуулж байна.

Хүснэгт 1.Төслийн ерөнхий мэдээлэл

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгч:	“Эйч Ди Ти Эм ” ХХК “ Хаягдал төмрийг хайлуулж ган туйван боловсруулах үйлдвэр” төсөл
1.2	Регистрийн дугаар:	РД: 5748305
1.3	Улсын бүртгэлийн дугаар:	УБД: 9019071144
1.4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 7-р хороо, бадрал 9, 8 тоот Утас: 889761677
1.5	Газар эзэмших эрхийн гэрчилгээ:	Дүүргийн Засаг даргын захирамжийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/378 тоот шийдвэрийн үндэслэн 88051 м.кв талбайг 5 жилийн хугацаатай эзэмшсэн.
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	“ Эйч Ди Ти Эм” ХХК-ийн Улаанбаатар хот Налайх дүүргийн 3-р хороонд байрлах “Хаягдал төмрийг хайлуулж ган туйван боловсруулах үйлдвэр ” төсөл
2.2	Төслийн байршил	Төслийн байршил нь Улаанбаатар хотоос 35 км, Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд байрлана. Газрын байршил нь үйлдвэрлэлийн районд оршдог бөгөөд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна.

		ТӨСЛИЙН ТАЛБАЙГААС 1000 МЕТРТ Танх тэмдэг - Эргэтийн цэг - Төслийн талбай - Төслийн талбайгаас 1000 метрт Масштаб 1:3 000 Координатын систем: WGS 1984 UTM Zone 48N
2.3	Төслийн зорилго	Хоёрдогч түүхий эд болох хаягдал төмрийг эдийн засгийн эргэлтэд оруулж цахилгаан индукцийн зуухны тусламжтайгаар хайлуулж дахин боловсруулан ган туйван үйлдвэрлэж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль дүрмийн хүрээнд аюул осолгүй, байгаль орчинд ээлтэйгээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах замаар төслийн үнэ цэнэ, үр ашгийг нэмэгдүүлж, ашиглалтын зардлыг боломжит бага байлгаж, Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, импортыг орлох бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангаж, компанийнхаа санхүүгийн болон өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.
2.4	Төслийн технологи	<pre> graph LR A[ХХТ-ийг хүлээн авч ангилах, ялгах, боловсруулах.] --> B[Хайлах] B --> C[Цутгах] C --> D[Цувих] D --> E[Хөргөх] E --> F[Тайрах ба баглах] </pre>
2.5	Төслийн хүчин чадал	6000 тн/жил ган туйван үйлдвэрлэнэ. Жилд 160 хоног ажиллана. Жилд 6 сар бүтэн ажиллах ба сард 26 хоног ажиллана. Үйлдвэр 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.
		Хатуу хог хаягдал: Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 111.8, жилд 17.9 тн орчим хаягдал гарах бөгөөд харьяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-тэй

2.7	Төслийн хог хаягдал	байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна. Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана. ✚ Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд ✚ Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна. Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай 
		Шингэн хог хаягдал: Нийт 130 ажилтантай гэж үзвэл хоногт 10.4 м³, жилд 160 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 1664 м³/жил болно. Хийн хаягдал: Үйлдвэрийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.

	Үйлдвэрийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 1481.7 тн /жилд 493.9 тн/ дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, СО-0.000148 тн, нүүрстөрөгч-0.000445 тн, NO2– 0.00005927 тн, SO2-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хорт хий ялгарахаар байна.
--	--

1.2 Төслийн байршил:

“Хаягдал төмрийг хайлуулж ган туйван боловсруулах үйлдвэр” төслийн талбай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлана.

Хүснэгт 2. Газар эзэмшигчийн мэдээлэл

1. Газар өмчлөгч, эзэмшигчийн овог нэр, регистрийн дугаар

“Эйч Ди Ти Эм” ХХК РД: 5748305

2. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн харьяалал:

Аймаг (нийслэл): Улаанбаатар хот

Сум (дүүрэг):Налайх

3. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Дүүргийн Засаг даргын захирамжийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/378 тоот шийдвэрийн үндэслэн 88051 м.кв талбайг 5 жилийн хугацаатай эзэмшсэн.

4. Байршил, хаяг: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо

5. Нэгж талбарйн дугаар: 1261610811

6. Гэрчилгээний дугаар: 0000243681

7 Түрээсийн талбайн хэмжээ /м2/: 8851


Хүснэгт 3. Газарзүйн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	107°18'8.0"	47°44'0.16"
2	107°18'8.04"	47°43'50.42"


3	107°18'21.86"	47°43'48.03"
4	107°18'22.01"	47°43'57.93"



Зураг 1. Төслийн байршлын нэгж талбарын хил



Зураг 2. Төслийн ерөнхий байршил



Зураг 3. Төслийн талбайн засаг захиргааны зураглал



Зураг 4. Төслийн харагдах байдал №1



Зураг 5.Төмрийн хаягдал цуглуулсан байдал №3

1.3 Төслийн дэд бүтцийн хөгжил, барилга байгууламж

1.3.1 Цахилгаан хангамж:

Цахилгааны эх үүсвэр нь төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон. Үйлдвэрийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах үүднээс хашаандаа 1000 Вт-ын 4, 630 Вт-ын 2 трансформатортай. Мөн орчин үеийн дэвшилтэт технологи болох гармоникын шүүлтүүрийг дэд станцад суурилуулсан.



Зураг 6. Цахилгаан үүсгүүр

1.3.2 Дулаан хангамж:

Хайлах үйлдвэр болон бусад барилга байгууламжийн халаалтын систем нь жилийн хүйтний улиралд тодорхой нэгэн эрчим хүчний тусламжтайгаар дулааны эрчим хүч үйлдвэрлээд түүнийгээ /дулаан зөөгч/ дамжуулах хоолойн тусламжтайгаар өрөө тасалгаанд байх халаах хэрэгсэлд хүрч дулааныг тухайн өрөөнд өгч халаах үйл ажиллагаа юм.

Тухайн барилга, өрөө тасалгаанд тавигдсан халаах хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс ялгарч буй дулаан, уг барилгын дулаан алдагдалтай тэнцүү байна. Халаалтын системийг хүйтний улиралд буюу гадна агаарын температур $+8^{\circ}\text{C}$ -10°C -аас тогтвортой буурч эхлэхэд халаалтыг ажиллуулж, хавар $+8^{\circ}\text{C}$ -аас тогтвортой дээшилж эхлэхэд халаалтыг зогсооно. Халаалт өгөх хугацаа: 10 сарын 1-ээс 5 сарын 1 хүртэл гэж тусгасан болно.

Төсөлд шаардлагатай дулаан хангамжийг шийдэхдээ халаалтын системийг бүрэн цахилгаанаар ОХУ-ын Мега хит маркийн цахилгаан суурин халаагуурууд ашиглана. Барилгын өрөөний хуваарилалт зэргээс хамааран 0.4 кВт-н халаагуур, 0.9 кВт-н халаагуураар хангана.

1.3.3 Ариун цэврийн байгууламж:

Тус үйлдвэр нь нүхэн жорлон ашигладаг.




Зураг 7. Төслийн ариун цэврийн байгууламж.

Сайжруулсан нүхэн жорлонгийн стандартын шаардлагыг хангуулахыг зөвлөж байна. Мөн дүүргийн төв цэвэрлэх байгууламж руу соруулан нийлүүлж байхыг зөвлөж байна.

1.3.4 Цэвэр болон бохир усны шийдэл:

Уг төслийн талбай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд байрлах бөгөөд цэвэр болон бохир усан хангамжийн хувьд төвийн шугамд холбогдоогүй. Өөрийн гүний худгаас усны хэрэглээг хангана. Худгийн усны ундарга 7.0 л/с байна.

1.3.5 Төслийн барилга байгууламж:



Тайлбар:

- | | |
|--|--------------------------------|
| 1-Хаягдал төмөр хайлуулах үйлдвэр | 14-Цахилгаан станц |
| 2-Үйлдвэрийн тээврийн зам | 15-Агуулах |
| 3-Түүхий эд буулгах талбай | 16-Ажилчдын амрах байр |
| 4-Түүхий эд буулгах талбай | 17-Ажилчдын хоолны газар |
| 5-Түүхий эд буулгах, пресслэх хэвнц оруулах | 18-Оффис |
| 6-Хяналтын байр /түүхий эд авах/ | 19-Авто зогсоол |
| 7-Түүхий эд авах хэсгийн агуулах | 20-Засвар үйлчилгээний хэсэг |
| 8-Оффис | 21-Сэлбэгийн агуулах |
| 9-Хяналт удирдлагын байр | 22-Ажилчдын байр |
| 10-Хяналт удирдлагын байр Төмөр хайлах үйлдвэр | 23-Харуул хамгаалалтын байр |
| 11-Оффис | 24-Үйлдвэрийн хашаа |
| 12-Авто пүү | 25-Түүхий эдийн нөөцийн талбай |
| 13-Аваар, ослын үед цуглах нэг | |

ТАНИХ ТЭМДЭГ:

- | | |
|--|-----------------------------------|
| | Үйлдвэрийн талбай доторх авто зам |
| | Бетонон зам |
| | Үйлдвэрийн хашаа |
| | Гүний худаг |



Зураг 8. Худаг

1.4 Ус ашиглах тооцоо:

Төслийн баг байнгын 130 ажилчинтай байна. Үйлдвэр жилд нийт 160 хоног ажилладаг. Хайлах үйлдвэрийн технологи болон ажилчдын унд ахуйн хэрэглээ болон ногоон байгууламжийн хэрэгцээний усыг худгаас хангах ба худаг дотор гүний насос байршуулан ашиглана. Ундны усанд байнга шинжилгээ хийж, хяналт тавьж байх шаардлагатай. Ялангуяа ундны усны нөөцийн савнаас эрүүл ахуйн байнга шинжилгээ авах, ундны усанд улирал болгон бактериологи болон хүнд металлын шинжилгээ, ерөнхий химийн шинжилгээ хийлгэх шаардлагатай.

Ус ашиглах үйлдвэрийн хүчин чадал:

Хайлах үйлдвэр нь 6000 тн/жил ган туйван үйлдвэрлэнэ. Жилд 160 хоног ажиллана. Жилд 6 сар бүтэн ажиллах ба сард 26 хоног ажиллана. Үйлдвэр 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.

“Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 14 дүгээр хавсралт “Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын усны норм”-д зааснаар албан байгууллагад 1 ажилтны хоногийн дундаж усны хэрэглээ нь 80 л болно.

Хүснэгт 4. Ахуйн ундны усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Норм,	Усны зарцуулалт
---	-------------	-------	-----------------

			л/хоног	Хүний	Хоногт	хэрэглэх	ус	Жилд	м3/жи
			г	тоо,	м3/хоног			ажилла	л
								х хоног	
1	Ахуйн	усны	80	130	10.4			160	1664
	хэрэглээ								
	Нийт			130				160	1664

Жилд нийт унд ахуйн ус хэрэгцээнд 1664 м3 ус ашиглана.

Технологийн усны хэрэглээ:

Хайлах үйлдвэрийн технологи болон ажилчдын унд ахуйн хэрэглээ болон ногоон байгууламжийн хэрэгцээний усыг өөрийн гүний худгаас хангана. Гүний худгийн усны ундарга нь 7.0 л/с байна.

Хайлах үйлдвэр нь 6000 тн/жил ган туйван үйлдвэрлэнэ. Жилд 160 хоног ажиллана. Жилд 6 сар бүтэн ажиллах ба сард 26 хоног ажиллана. Үйлдвэр 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.

Худгаас хайлах үйлдвэрийн дэргэд байгуулагдах технологийн цэвэр усны санд хуримтлуулан тэндээс үйлдвэрийн хэрэгцээний усыг насосын тусламжтай үйлдвэрт тэжээнэ. Хөргөлтийн усан сангаас 10 хувийн усны алдагдалтай бөгөөд эргэлтийн усан сангийн системтэй байна.

Хоног тутамд үйлдвэрлэн гарах халуун, улайдмал бүтээгдэхүүнийг хөргөхөд, усан сангийн усны 10% нь ууршин алдагддаг бөгөөд усан сангийн усыг сэлбэх үүднээс 12.7 м3 орчим усаар сэлбэлт хийж, бохирдолтоос хамааруулан хагас жилд нэг удаа бүрэн солих шаардлагатай юм. Түүнчлэн үйлдвэрийн тасралтгүй цутгах хэсэгт халуун хайлмагийг хөргөж гулдмай болгох зориулалттай хөргөлтийн систем байдаг бөгөөд хоногт дунджаар 127 м3 ус зарцуулдаг.

“Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оос

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН УСНЫ НОРМ

№	Үйлдвэр	Бүтээгдэхүүний нэр, хэмжих нэгж	Нийт ус хэрэглээ, м³	Үүнээс		
				Технологийн хэрэгцээнд, м³	Ахуйн хэрэгцээнд, м³	Техникийн хэрэгцээнд, м³
1	Гангийн үйлдвэр	тонн ган	3.5	0.7	0.1	2.7

Хүснэгт 5 .Нийт усны хэрэглээ

Үзүүлэлтүүд	Нийт ажиллах хоног	Жилийн хүчин чадал	Норм	Жилд нийт усны хэрэглээ	Хоногт хэрэглэх усны хэрэглээ
Нийт технологийн усны хэрэглээ	160	6000тн	3.5 м3/т	21000м3	131.25 м3
Цэвэр усны сэлбэлт	10%				12.7 м3

Ногоон байгууламж усны хэрэглээ:

Ногоон байгууламжид ашиглах ус: Газар эзэмшигч нь Монгол улсын газрын тухай хуулийн 56.6-д заасны дагуу тухайн аж ахуйн эзэмшил газрынхаа өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10%-аас доошгүй талбайд ногоон байгууламж байгуулах шаардлагатай гэж заасны дагуу ногоон байгууламж байгуулахаар төлөвлөсөн. Ургамалжуулахад хялбар, арчилгаа бага шаардах болон зардал тухайн талбайн үндсэн ургамалжилтын хэв шинжийг тооцон Хайлаас /Ulmus/ тарихаар төлөвлөсөн. Иймээс ногоон байгууламжийн усалгааг навчит модны нэг удаагийн усалгаагаар буюу нэг суулгацыг нормын дагуу буюу 40 литр, ургамлын ургалтын хугацаанд буюу 4-10 сарын хугацаанд сард 2 удаа, жилд нийт 12 удаа усалгаа хийнэ.

Жилд 20 ш модны суулгац*0.04 м3 ус* 12 удаа = 9.6 м3

“Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралт “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-д зааснаар нэг ширхэг суулгацын усалгааны горим 40.0 л байна.

Хүснэгт 6. Ногоон байгууламжийн усны тооцоо

№	Усалгаа хийх жил	Норм, л/хоног	Хамрах нэгж	Усны зарцуулалт 1 удаа услах ус м3/хоног	Жилд услах тоо	м3/жил
1	2025 он	40л/1ш	20ш	0.8	12	9.6
2	2026 он	40л/1ш	20ш	0.8	12	9.6
3	2027 он	40л/1ш	20ш	0.8	12	9.6
4	2028 он	40л/1ш	20ш	0.8	12	9.6

5	2029 он	40л/1ш	20ш	0.8	12	9.6
	Нийт	-	100ш	-	12	48

Нийт усны хэрэглээ:


Хүснэгт 7. Нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Норм, л/хон ог	Хүний тоо,	Усны зарцуулалт			Жилд ажилл ах хоног	м3/жи л
				Хоногт м3/хоног	хэрэглэх ус			
1	Ундны усны хэрэглээ	80	130	10.4			160	1664
2	Технологийн нийт усны хэрэглээ			131.25			160	21000
3	Ногоон байгууламж усны хэрэглээ	40л/1ш	20ш	0.8			12	9.6
4	Цэвэр усны сэлбэлт	10%						12.7
	Нийт							22686.3

Худгийн ундарга: Усны ундарга 7.0 л/с байна.

Худгийн байршил:

№	Уртраг	Өргөрөг
Худгийн координат	107°18'12.11"	47°43'53.25"



Зураг 9. Төслийн талбайн худгийн байршил

1.5 Төслийн технологи, техник тоног төхөөрөмж

Хүснэгт 8. Тоног төхөөрөмжийн хүчин чадал, зураг

№	Нэр	Марк	Хүчин чадал	Тоо	Зориулалт
А. ХХТ-ийг ангилах, ялгах, боловсруулах төхөөрөмжүүд					
1	Цахилгаан авто пүү	GL-100	100 тн	1	Түүхий эдийг жигнэж хүлээн авах
2	Гидро таслагч	QY-40	5 тн/цаг	2	Төмрийг тайрах
3	Механик жин	GL-100	500 кг	1	Жигнэх
4	Автоген багаж	GL-10	1тн/цаг	5	Төмөр таслах
Б. Хайлуулах хэсэг					
6	Цахилгаан индукцийн зуух	RGPS-250	2500 кг/цаг	5	Ган болон төмөр хайлах
7	Гүүрэн кран	GM-5	5тн	1	Ган хайлт өргөх
В. Цутгах хэсэг					
8	Гүүрэн кран	GM-10	10 тн	1	Ган хайлмагийн юүлүүр өргөх
9	Тасралтгүй бэлдэц цутгах машин	SZM	10 тн/цаг	1	Бэлдэц цутгах
10	Таслагч машин	SLM	20 ш/мин	1	Халуун бэлдцийг тайрах
Г. Цувих дамжлагын хэсэг					
11	Халуунаар цувих машин /ган туйван/	QY-604	2 тн/цаг	1	10-29 мм-ийн ган туйван цувих
12	Халуунаар цувих машин /катанка/	QY-304	10 тн/цаг	1	6.5-12 мм-ийн ган туйван цувих
Д. Хөргөх хэсэг					
13	Хөргөх тавцан	-	40 м	1	Хөргөх
14	Хөргөх тавцан	-	30 м	1	Хөргөх

Хэмжих, тайрах, баглах хэсэг					
15	Ган туйван таслагч	QY-30	30 м	1	Таслах
16	Ган туйван таслагч	QY-20	20 м	1	Таслах
17	Ган туйван шилжүүлэх ролик	-	30 м	2	Ган туйван дамжуулах
20	Ган туйванг баглах төхөөрөмж	TY-13	30 мм	1	Баглаж боох
Е. Ачаа зөөн, шилжүүлэх, ачих тоног төхөөрөмж.					
21	Тээврийн хэрэгсэлд ган туйван ачих кран	SM-5	5 тн	1	Ачих
Ё. Бусад					
22	Өндөр хүчдэлийн 10кВ-ын агаарын шугам	10кВ	10 кВ	1300 м	Цахилгаан эх үүсгэврийг хангах
23	Трансформатор	TM-1000	10/0.4 кВ	2	Хүчдэл бууруулах
24	Трансформатор	TM-630	10/0.4 кВ	1	Хүчдэл бууруулах
25	Гармоник шүүлтүүр	-		1	Цахилгаан хүчдэл жигдрүүлэгч
26	Гүний худаг	-	83 м	1	Усны эх үүсвэрийг хангах
27	Хөргөлтийн усан сангийн систем, насос	QY-25	25 м3/цаг	6	Ус шахах
28	Усан сан	-	800 м3	2	Ус хөргөх

Цахилгаан индукци зуухны давуу тал



1.6 Цутгамал ган эдлэлийн технологийн шат дамжлагууд

Зураг 10. Ган туйвангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн байршлын шав дараалал



1.7 Төслийн эцсийн бүтээгдэхүүн буюу ган туйван



Зураг 11. Төслийн эцсийн бүтээгдэхүүн

Ган туйвангийн стандарт

Барилгын үндсэн материалын нэг болох төмөрбетон бүтээцийн ган туйвангийн үндэсний MNS JIS G 3112:2002 стандартыг анх 2002 онд “Төмөрбетон бүтээцийн ган туйван” нэртэйгээр боловсруулж баталгаажуулаад мөрдөж байна.

Энэхүү стандарт нь Япон Улсын JIS G 3112:1987 стандарт дээр суурилагдан боловсруулагдсан бөгөөд олон улсын болон бусад орны стандартын шаардлагын түвшинг ерөнхийдөө хангаж ирсэн боловч манай улсын импортын гол нийлүүлэлтийг хийдэг ОХУ, БНХАУ болон олон улсын стандартын үзүүлэлтээс нэлээд ялгаатай байдаг.

Иймд барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, хийцийн даацын тооцооллыг хийхэд тодорхой хэмжээний бэрхшээл тулгарсаар ирсэн бөгөөд манай улс дотооддоо барилгын ган туйванг үйлдвэрлэж байгаа боловч ихэнх хэрэгцээгээ ОХУ болон БНХАУ-аас импортоор хангаж байна.

Барилгын ган туйван нь барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн төмөрбетон эдлэл, хийцийн даацыг тодорхойлдог, барилгын чанарт онцгой нөлөөтэй гол материал тул импортын ган туйвангийн чанарыг одоо мөрдөж байгаа үндэсний стандартаар тодорхойлоход саад бэрхшээл учирч байна.

Монгол Улсын ган туйвангийн стандартыг хүснэгт 9-т үзүүлээ.

Хүснэгт 9. Монгол Улсын ган туйвангийн стандарт

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ	
Төмөр бетон бүтээцийн ган туйван.	MNS JIS G 3112:2002
Steel bars for the reinforcement of concrete	
Ангилалтын код: 77.140.15	

Энэхүү стандартаар төмөр бетон бүтээцэд ашиглах зорилгоор халуунаар цувих аргаар үйлдвэрлэсэн төмөр бетон бүтээцийн гөлгөр ба иржгэр ган туйвангийн техникийн шаардлагыг тогтооно.

1.8 Тэрбум мод мод тарих хөтөлбөрийн хүрээнд хийх ажлууд

Тус “Эйч Ди Ти Эм” ХХК-ийн “Хаягдал ган төмрийг хайлуулж ган туйван боловсруулах үйлдвэр” төслийн хүрээнд 2025-2029 онд тэрбум мод аяны хүрээнд нийт 250ш мод тарихаар төлөвлөж өглөө.

Хүснэгт 10.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дараагийн 5 жилд тарих модны тооцоолол

№	Тарих модны төрөл	Тариалах газар	Ач холбогдол	Тарих тоо хэмжээ, ш	Үнэ 2025 оны байдлаар, төг	Тариалах хугацаа, он	Авах боломжтой газар
1	Улиас	Налайх дүүрэгт Нийслэлээс зааж өгсөн мод үржүүлгийн газарт	Улиас нь бургасны овогт хамаарна, фитоцонид хэмээх агаарыг цэвэршүүлэх бодисыг их агуулдаг тул хот сууринд тарьж ургуулахад тохиромжтой.	200ш	4 нас /1.5м/ - 5000*200=2,000,000	2025-2029	Багануур дүүргийн БАГАНУУР-ОЙ мод үржүүлгийн газар /2005 оноос тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна/.
2	Нарс		Нарс нь хоосон үржил шимгүй хөрс шороо, тэр ч байтугай хад хясаан дээр ч ургаж чаддаг. Нарс мод хүний дархлааг нэмэгдүүлж, интерферон хэмээнх бодис ялгаруулдагаараа бусад модноос онугуй ялгардаг.	50ш	100,000*50=5,000,000	2025-2029	
Нийт тоо, хэмжээ				250ш	7,000,000		

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

2.1. ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ШААРДЛАГА

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

БОМТ-г боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 дугаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдлага болгон боловсруулав.

2.2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Бүрд констракшны гэр хорооллын дахин төлөвлөлт” ХХК-иас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй болно.

Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

2.3. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Эйч Ди Ти Эм” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Эйч Ди Ти Эм” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох

төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцах болно.

Хүснэгт 11. БОМТ хэрэгжүүлэх зардал

Д/д	Авах арга хэмжээ	Тухайн жилийн зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх,бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,000,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө	1,500,000
3	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	500,000
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,800,000
5	Орчны хяналт шинжилгээ	445,000
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,500,000
	Дүн, төгрөг	7,745,000

БҮЛЭГ 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг /мян. төг/	Зардал /мян. төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар						-		
Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрээс ялгарах хорт хий	Авто тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх	Тээврийн хэрэгсэл	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
Гадаргын ус болон газрын доорх ус								
Газрын доорх усны нөөц багасах, бохирдох	Усны төлбөрийг заалтын дагуу хугацаанд нь төлөх	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам (БОНХ-ийн сайдын 2013 оны 5 сарын 16-ны өдрийн А-156 дугаа тушаалын хавсралт)
Газрын гадарга, хөрс						1,200.0		
Шатах тослох материал асгарч хөрсийг бохирдуулах	Эвдрэлтэй тээврийн хэрэгслийг цаг тухайд нь засвар, үйлчилгээнд оруулж байх, хэрэв хөрс	Талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгах				2026 он	Асгаралтын хариу арга хэмжээний журам OHSE.ER.602

	шатах, тослох материалаар бохирдсон бол тухай бүрд нь зохих стандартын дагуу ариутгаж, цэвэрлэх						MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ.
	Технологийн хаягдал тос хадгалах цэгийн эмх цэгц	Технологийн хаягдал тос хадгалах цэг	Үйл ажиллагааны зардалд тусгах				
	Автомашины байнгын зогсоолын талбайг тохижуулах	Талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгах			2026 он	MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
Газрын чанарын хянан баталгааны дүгнэлт гаргуулах		Төсөл	2,000			2026 он	Ажлын үнэлгээ шинэчлэн батлах тухай хууль
Ургамал						-	
Ургамлан нөмрөг хүн болон тээврийн хэрэгслийн нөлөөгөөр устах, сийрэгжих, улмаар энэ нь ургамал нөмрөг их хэмжээгээр алдралд орох эх үүсвэр болж болно.	Ногоон байгууламжийн талбайд арчилгаа, тордолгоо, усалгааг тогтмол хийх.	Ногоон байгууламжийн талбайд	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026 он	-Ургамал хамгааллын тухай” хууль: Зүйл 8-1, 2 -Байгалийн ургамлын тухай” хууль: Зүйл 7. Ургамлыг хамгаалах; -MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”
Нийт			1,200.0				

БҮЛЭГ 4. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг /мян. төг/	Зардал /мян. төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ногоон байгууламжийг арчилж, хамгаалах	Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах	Төслийн талбай	-	50	1,500.0	1,500.0	2026 он	Ургамал хамгааллын тухай хууль
Нийт						1,500.0		

БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн эзэмшил газрын ойр орчимд тусгай хамгаалалттай газар нутаг болон түүх, соёлын дурсгалт зүйлс байхгүй. Тус төслийн барилгын ажлын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

БҮЛЭГ 6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осолсөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг) 2025	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй						
Үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөлтэй холбоотой ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Ажилчдын ажлын байрны нөхцөлтэй нь уялдуулан аюулгүй ажиллагааны, хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	Нийт ажилчид	Үйл ажиллагааны зардалд оруулах		-	ХАБЭА-н бодлого, заавар журам, стандарт, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль
	Дархлаа дэмжих, хор саармагжуулах эрүүл ахуйн шаардлага бүтээгдэхүүнээр хангах				Ажлын өдрүүдэд	
Гал түймэр	Гал гарч болзошгүй объектуудын ойролцоо ил гал гаргах, тамхи татахыг хатуу хориглох, хянах	Ажлын байр, хаягдал тос хадгалах хэсэг	Зардал шаардахгүй		Үйл ажиллагааны турш	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, журам, галын аюулгүй байдлын тухай хууль
	Болзошгүй галын аюулын үед ашиглах гал унтраах хэрэгсэл, материалыг шаардлагатай газар бэлэн байлгах	Ажлын байр	500.0	500.0	Үйл ажиллагааны турш	
	Ажилчдад галын аюулын үед авах арга хэмжээний талаарх сургалтыг явуулах	Нийт ажилчид	ХАБЭА-н сургалт, сурталчилгааны зардлаар		Төлөвлөгөөний дагуу	
Нийт			500.0			

БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал (мян.төг) 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, арга аргачлал
Хог хаягдлаар орчныг бохирдуулах	Аюултай хог хаягдлыг зайлуулахдаа тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Техникийн хаягдал тос, аккумулятор	-	-	Тогтмол	-Хог хаягдлын тухай хууль -Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943: 2011
	“Хог хаягдал хадгалах зориулалтын цэг”-ийг зонхилох салхины доод зүгт байрлуулж, салхинд хийсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн,хөрсөнд шингээлт үүсэхээс хамгаалсан байх	Хог хаягдлын цэг	-	-	Тогтмол	
	Битүүмжлэл сайтай, ангилан ялгах зориулалттай хогийн сав	Хог хаягдлын цэг	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	
	Хог хаягдлыг тогтоосон цэгт зохих шаардлагын дагуу хадгалж, хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах	Хог хаягдал	150.0	1,800.0	Сард 1 удаа	
	Хог хаягдлын цэгт хийх ариутгал, халдваргүйжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Хогийн цэг	-	-	Улиралд 1 удаа	
Нийт			1,800.0			

БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Эйч Ди Ти Эм” ХХК -ийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан чухал баримт бичиг юм.

Үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Эйч Ди Ти Эм” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага (Нийслэлийн байгаль орчны газар)-т хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Үйл ажиллагаанаас агаар, ус, хөрс, ургамалд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Ажлын хэмжээ	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаар					270.0	
Агаарын түгээмэл бохирдуулагч болох хүхэрлэг хий (SO ₂), азотын давхар исэл (NO ₂), нийт тоос, Дуу шуугианы хэмжилт	Төслийн талбайд	20 минутын хэмжилт	Жилд 1 удаа, 1 цэгээс нийт 1 дээж	Шинжээчийн зардал 120.0 Шинжилгээний үнэ 150.0	270.0	-MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга -MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага -MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
Гадаргын болон газрын доорх ус					100.0	
Усны ерөнхий шинжилгээ	Өөрийн гүний худгаас	Жилд 1 удаа		Ерөнхий химийн 100.0	100.0	MNS4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
Хөрс					75	
Хөрсний хими физик шинж чанар, хүнд металлын шинжилгээг хийлгэх	Төслийн талбайд -Хогийн цэг -Түүхий эд хүлээн авах орчимд 2 цэг сонгох	Жилд 1 удаа, 1 цэгт	Жил бүрийн 7-8 сарын хооронд 0-15 см гүнээс 1 дээж авах	Хөрсний ерөнхий шинжилгээ 25.0 Хүнд металлын шинжилгээ 25.0 Эрүүл ахуй 25.0	75.0	-MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга -MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт						445.0

БҮЛЭГ 9. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь ISO 14001 2004 (MNS 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх-хэрэгжүүлэх-хянах-шийдэх гэсэн 4 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцлийг бүрдүүлдэг байна.

Тус газрын үйл ажиллагааны явцад байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, үйлдвэрийн удирдлага нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал (мян.төг) 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Бичиг баримт	Галын дүгнэлт, ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах гэрээ, зөвшөөрөл гаргуулах	Удирдлага	-	-	Жилд 1 удаа
2		Байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд харъяа хороотой хамтран ажиллах.	Удирдлага	-	-	Жилд 1 удаа
3	БОМТ биелэл/хэрэгжилт болон дараа оны БОМТ тайлан бэлтгэх, тайлагнах, батлуулах		Удирдлага	-	-	Жилд 1 удаа
Нийт				2000.0		

БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар Нийслэлийн байгаль орчны газарт тухайн жилийн тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг х жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг жил тутамд хийнэ.

Хүснэгт 18. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төрийн захиргааны төв байгууллага (Нийслэлийн байгаль орчны газар)	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний тайлантай хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11 дугаар сарын 01-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулах	НБОГ-т хүргүүлнэ
Хорооны иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 10 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Хорооны ИТХ

ХАВСРАЛТ

1. Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ
3. Батлагдсан зураг төсөл
4. Хөрсний шинжилгээ
5. Ерөнхий үнэлгээний дүгнэлт